



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 06 өдөр

Дугаар Б/НЧ

Улаанбаатар хот

Ээлжийн амралт олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2 дах хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дах хэсэг, Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.2, 8.3, 8.5 дах заалтууд, Газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер Г.Пүрэвдорж, Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Үйл ажиллагааны төлөвлөлт хариуцсан эдийн засагч С.Ариунбилэг, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Түвшинзаяа, Мэдээллийн технологийн инженер Г.Цэнджав нарын ээлжийн амралтыг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2016 оны 08 дугаар сарын 04-ны өдрийг дуустал тус тус ажлын 15 өдрөөр олгосугай.

2. Г.Пүрэвдорж, С.Ариунбилэг, Т.Түвшинзаяа, Г.Цэнджав нарын ээлжийн амралтын мөнгийг холбогдох журмын дагуу олгохыг Нягтлан бодогч /Г.Батням/-д зөвшөөрсүгэй.

3. Ээлжийн амралтын мэдэгдэл хүргүүлэн ажил хүлээлцүүлж ажиллахыг Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн /П.Түвшинзаяа/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /А.Нямхүү/-д даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600044